



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2024/09/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: А.Нарандэлгэр Утас: 86001147 Цахим хаяг: narandelgera@audit.gov.mn
--	--

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2024.02.21 № 01/43

танай _____-ны № _____-т

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ
САНГИЙН ДАРГА
Л.БИЛЭГДЭМБЭРЭЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2015-2019 он хүртэл санхүүгийн дэмжлэгт хамрагдсан боловч хариуцагч нас барсан 32 иргэний 51.2 сая төгрөгийн холбогдох материалыг бүрдүүлэн шүүхийн шийдвэр гаргуулж, авлагын данснаас хасуулах саналтайгаар ХХҮЕГ-т хүргүүлсэн ч шийдвэр гараагүйн улмаас авлагад бүртгэлтэй хэвээр байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

2023 онд хугацаа хэтэрсэн зээлдэгчийн 286 иргэний 658,798.3 мянган төгрөгийн авлага барагдуулснаас 76 иргэний 146,477.1 мянган төгрөгийн зээлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлэн албадан төлүүлэх шүүгчийн захирамж гаргуулан, 45 иргэний 119,288.0 мянган төгрөгийн зээлийг Ховд аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн эвлэрүүлэн зуучлах албаны эвлэрлийн гэрээ байгуулан, 165 иргэний 393,032.7 мянган төгрөгийн зээлийг дотоод хяналт шалгалтаар мөрөөр тус тус төвлөрүүлэн ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,429,783,930.00	4,363,472,012.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	3,429,783,930.00	4,363,472,012.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	9,520,000.00	227,858,492.00
335	Бусад авлага	3,420,263,930.00	4,135,613,520.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,420,263,930.00	4,135,613,520.00
35	БАРАА МАТЕРИАЛ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,429,783,930.00	4,363,472,012.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	31,500,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	31,500,000.00
413	Өглөг	-	31,500,000.00
4136	Бусад өглөг	-	31,500,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	31,500,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,429,783,930.00	4,331,972,012.00
51	Засгийн газрын хувь оролцоо	3,429,783,930.00	4,331,972,012.00
512	Хуримтлагдсан үр дүн	3,429,783,930.00	4,331,972,012.00
51210	Өмнөх үеийн үр дүн	3,429,783,930.00	3,418,763,930.00
51220	Тайлант үеийн үр дүн	-	913,208,082.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,429,783,930.00	4,363,472,012.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,600,837,247.24	2,818,022,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,600,837,247.24	2,818,022,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,600,837,247.24	2,818,022,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,600,837,247.24	2,818,022,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	92,674,247.24	1,321,137,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	168,931,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	2,508,163,000.00	1,327,954,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,840,831,542.24	1,904,813,918.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,840,831,542.24	1,904,813,918.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,350,000.00	81,573,824.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,350,000.00	81,573,824.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,350,000.00	81,573,824.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,839,481,542.24	1,823,240,094.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	916,220,745.00	829,083,684.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	916,220,745.00	829,083,684.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	201,948,587.24	61,716,000.00

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	201,948,587.24	61,716,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	721,312,210.00	932,440,410.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	721,312,210.00	932,440,410.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>760,005,705.00</u>	<u>913,208,082.00</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>760,005,705.00</u>	<u>913,208,082.00</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	3,429,783,930.00	3,429,783,930.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-11,020,000.00	-11,020,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	3,418,763,930.00	3,418,763,930.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	913,208,082.00	913,208,082.00
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	4,331,972,012.00	4,331,972,012.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,603,502,247.24</u>	<u>2,818,022,000.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>2,603,502,247.24</u>	<u>2,818,022,000.00</u>
120	Нийтлэг татварын бус орлого	2,603,502,247.24	2,818,022,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,603,502,247.24	2,818,022,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,665,000.00	1,321,137,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	92,674,247.24	168,931,000.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	2,508,163,000.00	1,327,954,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,329,149,457.24</u>	<u>3,767,172,410.00</u>

21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,329,149,457.24	3,767,172,410.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,350,000.00	81,573,824.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,350,000.00	81,573,824.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,350,000.00	81,573,824.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,327,799,457.24	3,685,598,586.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,395,018,660.00	2,495,083,684.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,395,018,660.00	2,495,083,684.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	99,674,247.24	196,358,492.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	99,674,247.24	196,358,492.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	111,794,340.00	61,716,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	111,794,340.00	61,716,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	721,312,210.00	932,440,410.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	721,312,210.00	932,440,410.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(725,647,210.00)</u>	<u>(949,150,410.00)</u>
14	Бусад эх үүсвэр	725,647,210.00	949,150,410.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	725,647,210.00	949,150,410.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>725,647,210.00</u>	<u>949,150,410.00</u>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,787,806,000.00	2,576,657,508.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,787,806,000.00	2,576,657,508.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	87,500,000.00	81,573,824.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	87,500,000.00	81,573,824.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87,500,000.00	81,573,824.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,700,306,000.00	2,495,083,684.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,700,306,000.00	2,495,083,684.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,700,306,000.00	2,495,083,684.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,787,806,000.00	2,576,657,508.00
	Улсын төсвөөс санхүүжих	2,787,806,000.00	2,576,657,508.00

Хоёр . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 3,050.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс бүртгэл тайлагналын алдаа¹ илрээгүй болно.

Залруулагдаагүй нийт 3,050.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 3,050.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 500,0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 2,550.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1 зөвлөмжийг өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Байгууллагын үйл ажиллагаанд хамааралгүй ном худалдан авч төсөвт үргүй зардал гаргасан 500.0 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

1. Тараах материалыг төсвийн хөрөнгөөр бэлтгэхдээ зах зээлийн үнээс өндөр үнээр бэлтгэсэн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага тогтоосон.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Аж ахуй эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгээс түрээсийн хөнгөлөлт үзүүлэхдээ и-баримтаар баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Түрээсийн дэмжлэгийг үзүүлэх арга хэмжээнд хамрагдаж байгаа иргэдэд үзүүлэх дэмжлэгийг и-баримтыг үндэслэн олгож байх.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан													

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	3	4	5	6	7	8	9	10	11	12
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1	500	1	500						
	1	2,550.00			1	2,550.00				
	1	-					1	-		
	3	3,050.00	1	500	1	2,550.00	1	-		

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	-	1	-	-	1	-	-	-
НИЙТ			1	-	-	1	-	-	-